

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газрын 2019 оны
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/1/СТА-ОНӨААН

Цахим хуудас: www.audit.mn
(Дорноговь аймаг, Сайншанд сум)
2020 он

Тэргүүлэх аудитор:	Ч.Ариунаа
Утас: 70522734	Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn
Аудитын менежер:	Э.Энхцэцэг
Утас: 70523020	Цахим хаяг: enkhtsetseg.e@audit.gov.mn
Аудитор:	Ч.Батсэрээдэнэ
Утас: 99032916	Цахим хаяг: ij17.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан.....	5
2.1.	Оршил.....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8.	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	8
2.9.	Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ...	9
2.10.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	10
2.11.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.12.	Шилэн дансны мэдээлэл	10
2.13.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13.	Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал	11
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	14

1 Аудитын гэрчилгээ

 ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34 Бэб сайт: dornogovi@audit.gov.mn <u>2020.03.13</u> № <u>1-6/328</u> танай _____-ны № _____-т	ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА Ц.НАРАНЗУЛ ТАНАА
Аудитын гэрчилгээ	
Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.	
Санал дүгнэлт өгөхөөс татгалзах Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг үнэлж, Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангуудыг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль, тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлээгүй гэж дүгнэн санал дүгнэлт өгөхөөс татгалзаж байна.	
Санал дүгнэлтийн үндэслэл Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг. Аудитаар Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан. Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.	

Аудитын гол асуудал

Өмнөх оны аудитаар тус байгууллагын хариуцлагын хэлбэрийг тодорхой болгох албан шаардлага, холбогдох зөвлөмжийг өгсөн боловч асуудлыг шийдвэрлээгүй, алдаа, зөрчил дахин давтагдсан, ямар хэлбэрээр хариуцлага хүлээх нь тодорхой бус байхад 638,316.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, захиран зарцуулсан байна. Тус байгууллагаас асуудлыг шийдвэрлүүлэхээр өгсөн 2019 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 44 тоот, 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 74 тоот албан бичгүүдийн хариуг аймгийн Засаг даргын тамгын газраас 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 3/299 тоотоор ирүүлсэн бөгөөд тус бичигт "энэ асуудал нь тодорхой шийдэлд хүрч чадаагүй учраас байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг хуучин хэвээр нь явуулж байгаа" гэсэн байна.


Энэ нь санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт, эрх ба үүрэг, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна, Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.34 заалт, 5 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4 заалтыг тус тус зөрчсөн байна.

Үүрэг, хариуцлага

Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газрын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг дарга Ц.Наранзулд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газрын 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газрын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС/УСНББОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 2 дугаар сарын 11-ээс 2020 оны 2 дугаар сарын 14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын захиалгаар Ингүүмэл жаргалант аудит ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Нийтлэг үйлчилгээний газар 2019 оны санхүүгийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 2 дугаар сарын 19-ны өдрийн 21 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС,НББОУС, УСНББОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газар нь олон улсын стандартын шаардлага хангасан, чанартай нийтлэг үйлчилгээ үзүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Байгууллагын үүсгэн байгуулах баримт бичигт зааснаар үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төсөвт байгууллагуудад эд хогшил, бараа материал захиалгаар нийлүүлж үйлчлэх.
- Хэвлэх цех.
- Цэвэрлэгээний үйл ажиллагаа.
- Тээвэр үйлчилгээ.
- Харуул хамгаалалтын үйл ажиллагаа.

Байгууллагын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газрын удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Компаний тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчинд томоохон өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

Байгууллагын даргын 2003 оны 33 тоот тушаалаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг батлан мөрдөж байгаа боловч байгууллагын хариуцлагын хэлбэрт нийцээгүй, үндэслэл болгосон зарим хууль, заавар, журам хүчингүй болсон байна.

Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газар нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн "Leader" программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 32 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогын 0.2 хувиар сонгов.

Нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь өөрийн орлогод тулгуурлан үйл ажиллагаа эрхэлдэг ашгийн бус байгууллага гэж тодорхойлсон байх тул материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгосонтой холбоотой юм.

2019 оны нийт орлого 638,316.6 мянган төгрөг бөгөөд түүний 0.2 хувь болох 1,276.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 0.2 хувиар тооцсон нь үйл ажиллагааны цар хүрээтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 17,738.6 мянган төгрөгөөр буюу 0.36 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/мянган төгрөгөөр/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,379.90	24,602.00	20,222.10
Авлага	2,064.60	3,304.50	1,239.90
Урьдчилгаа			-

Бараа материал	55,387.20	73,504.10	18,116.90
Үндсэн хөрөнгө	4,862,336.40	4,840,496.10	(21,840.30)
Нийт хөрөнгө	4,924,168.10	4,941,906.70	17,738.60
Өр төлбөр	11,127.60	10,382.60	(745.00)
Хувь нийлүүлсэн хөрөнгө	1,589,231.30	1,698,941.10	109,709.80
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,777,697.30	3,777,697.30	-
Хуримтлагдсан ашиг	(453,888.10)	(545,114.30)	(91,226.20)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,924,168.10	4,941,906.70	17,738.60

Авлага дансны үлдэгдэлд 2018 - 2019 онуудад үүссэн, нэг жил болсон 153.0 мянган төгрөгийн авлага, албан байгууллага /хувь хүнээс/ авах 399.6 мянган төгрөгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь оны эцэст 60,412.3 мянган төгрөгийн худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн нь нөлөөлж байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй хөрөнгө гэж байхгүй харин эвдэрсэн шаардлага хангахгүй болсон хөрөнгийг акталсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь 2019 онд фургон автомашин 33,000.0 мянган төгрөг, том оврын автобус 75,140.0 мянган төгрөг, наадмын үйл ажиллагаатай холбоотой 1,569.8 мянган төгрөгийн үнэтэй 2 ш хөлдөөгчийг аймгийн ЗДТГ-с хандиваар олгосноос шалтгаалсан байна. Байгууллага өөрийн хөрөнгөнөөс гражийн хаалга, нийгмийн ажилтанд шаардлагатай компьютер, иргэний танхимын сандлууд, Архивын ерөнхий газрын шаардлагын дагуу офсет хэвлэх машин зэрэг хөрөнгүүдэд 15,268.1 мянган төгрөг зарцуулсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл буурсан нь 2018 оны баяр наадмын арга хэмжээний үеэр үүссэн, аймгийн ЗДТГ-с төлөх ёстой татварын өглөг 10,000.0 мянган төгрөг, байгууллагын үлдэгдэл 1,100.0 мянган төгрөгийг тус тус төлсөнтэй холбоотой байна.

Хувь нийлүүлсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,698,941.1 мянган төгрөг болж өссөн нь аймгийн ЗДТГ-с хандиваар олгосон 109,709.8 мянган төгрөгийн хөрөнгө нэмж авсантай холбоотой байна.

2.9. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газар нь өөрийн үйл ажиллагаанаас 161,830.0 мянган төгрөгийн, аймгийн ЗДТГ-ын санхүүжилтээр 476,486.6 мянган төгрөгийн нийт 638,316.6 мянган төгрөгийн орлого олж 729,542.7 мянган төгрөгийн зардал гаргаж 91,226.1 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. 2019 онд байгууллага хэдэн төгрөгийн орлого олохоор төлөвлөсөн, орлогыг юунд зарцуулах талаар батлагдсан төлөвлөгөө байхгүй байна.

2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 5 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 639,892.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгч байна.

Аудитаар илэрсэн мянган төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар байгууллагын хариуцлагын хэлбэрт нягтлан бодох бүртгэл хэрхэн нийцэж байгаа асуудлыг авч үзэх нь зүйтэй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний нь шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар 149 мэдээлэл байршуулахаас 148 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 1 албан шаардлага, 14 зөвлөмж өгөгдсөн бөгөөд 2019 оны жилийн эцсийн байдлаар албан шаардлагыг биелүүлээгүй, 10 зөвлөмжийг биелүүлсэн, 2 зөвлөмжийн биелэлт 50%-тай, 2 зөвлөмжийг биелүүлээгүй байна.

2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газрын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Санал дүгнэлт өгөхөөс татгалзах” дүгнэлт

Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Өмнөх аудитаар байгууллагын хариуцлагын хэлбэрийг тодорхой болгох албан шаардлага, холбогдох зөвлөмжийг өгсөн боловч асуудлыг шийдвэрлүүлээгүй, алдаа, зөрчил дахин давтагдсан, ямар хэлбэрээр хариуцлага хүлээх нь тодорхойгүйгээр 638,316.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэн, захиран зарцуулсан байна.
2. Байгууллагын даргын 2003 оны 33 тоот тушаалаар баталсан НБББББ-г мөрдөн ажиллаж байгаа бөгөөд тус баримт бичиг нь одоогийн шаардлагад бүрэн нийцэхгүй байна.
3. Байгууллагын удирдлагын шийдвэрийн дагуу нягтлан бодогч бэлэн мөнгөний орлого, зарлагын баримт /НХМаягт МХ-1, 2/-г бичдэггүй өөрөөр хэлбэл 1, 2 дугаар гарын үсэг зурагдсан баримтгүй байхад мөнгөний нярав гүйлгээ хийдэг байна.
4. Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн, өөрчлөлтийг бараа материалын тайлан /НХМаягт БМ-9/-р үнийн дүнгээр тайлагнасан байна.
5. Ээлжийн амралтын тооцоо, ээлжийн амралт олгох тухай мэдэгдлийг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалаар баталсан заавар, маягтын дагуу тооцдоггүй байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг нотлох баримтын хамт Төрийн аудитын газарт 2020 оны 5 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

3.1 Өмнөх аудит болон зөвлөмжийн биелэлт, үр дүн.

3.1.1 Илрүүлэлт:

Өмнөх аудитаар байгууллагын хариуцлагын хэлбэрийг тодорхой болгох албан шаардлага, холбогдох зөвлөмжийг өгсөн боловч асуудлыг шийдвэрлүүлээгүй, алдаа, зөрчил дахин давтагдсан, ямар хэлбэрээр хариуцлага хүлээх нь тодорхойгүйгээр 638,316.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэн, захиран зарцуулсан байна

Энэ нь эрх ба үүрэг, үнэлгээ ба хуваарилалт, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.34, 5 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 2.4 заалтыг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Өмнөх аудитын зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг бүрэн хэрэгжүүлээгүй, алдаа зөрчлийг давтан гаргасан байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Байгууллагын хариуцлагын хэлбэр аймгийн ИТХ-с батлагдаагүй байхад орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн хэлбэрээр санхүүгийн тайлан бэлтгэсэн нь буруу гэж үзэж байгаа бөгөөд хэрэв орон нутгийн өмчит аж ахуйн нэгж гэж үзвэл Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу аймгийн ИТХ хүн амаа төлөөлөн өмчлөгч нь болох бөгөөд холбогдох эрхийг хэрэгжүүлдэг байна. Иймд байгууллагын хариуцлагын хэлбэрийг тодорхой болгох нь зүйтэй.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Дээд шатны байгууллагаар шийдвэрлүүлэх асуудал тул 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 22 тоот албан бичгээр аймгийн Засаг даргад дахин санал хүргүүлээд байна.

3.2 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл.

3.2.1 Илрүүлэлт:

Байгууллагын даргын 2003 оны 33 тоот тушаалаар баталсан НБББББ-г мөрдөн ажиллаж байгаа бөгөөд тус баримт бичиг нь одоогийн шаардлагад бүрэн нийцэхгүй байна.

Энэ нь эрх ба үүрэг, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9, 18 дугаар зүйлийн 18.2, 20 дугаар зүйлийн 20.2.2 заалтуудыг тус тус зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь тухайн байгууллагын онцлог, үйл ажиллагаатай уялдаагүй байх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

НБББББ-ийг холбогдох стандарт болон одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн боловсруулж, баталж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Шинэчлэх ажил хийгдэж байгаа, өөр санал байхгүй.

3.3 Балансын данстай холбоотой асуудал.

3.3.1 Илрүүлэлт:

Байгууллагын удирдлагын шийдвэрийн дагуу нягтлан бодогч бэлэн мөнгөний орлого, зарлагын баримт /НХМаягт МХ-1, 2/-г бичдэггүй өөрөөр хэлбэл 1, 2 дугаар гарын үсэг зурагдсан баримтгүй байхад мөнгөний нярав гүйлгээ хийдэг байна.

Энэ нь эрх ба үүрэг, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалыг зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Мөнгөн хөрөнгийг анхан шатны баримтгүй зарцуулсан байх.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Байгууллагын удирдлагын шийдвэрийн дагуу хариуцсан нягтлан бодогч бэлэн мөнгөний орлого, зарлагын баримтыг бичиж нэг, хоёрдугаар гарын үсэг зурагдсаны дараа мөнгөний нярав зохих гүйлгээг хийх. “Бэлэн мөнгөний орлогын баримт”-аар бэлэн мөнгийг тоолж хүлээн авч, зарлагын баримтыг үндэслэн бэлэн мөнгийг хүлээлгэж өгөх. Эдгээр баримтуудыг 2 хувь үйлдэж, мөнгө тушаагч эсвэл хүлээн авагч нарт 1 хувийг өгч, холбогдох баримт бичгийн хамт 1 хувийг нярав хадгалан “Бэлэн мөнгөний тайлан”-д бичилт хийх үндэслэл болгох. Бэлэн мөнгөний орлого, зарлагын баримтуудыг дагалдах баримт бичгийн хамт Бэлэн мөнгөний тайлангийн 1 хувьтай хавсарган, холбогдох нягтлан бодогчид тушаах. Бэлэн мөнгөний нярав тайлангийн 1 хувийг өөртөө хадгалах.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид анхаарч, баталгаажуулж ажиллана.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа.

3.4.1 Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн, өөрчлөлтийг бараа материалын тайлан /НХМаягт БМ-9/-р үнийн дүнгээр тайлагнасан байна.

Энэ нь үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаал тус тус зөрчсөн байна.

3.4.2 Эрсдэл:

Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн, өөрчлөлтийг хөтөлбөл зохих анхан шатны баримтгүйгээр тайлагнах.

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодогч Сангийн сайдын 2018 оны 100 тоот тушаалаар баталсан үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл /ҮХ-1/-г хөтлөхдөө Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан анхан шатны баримт болох ҮХ-1, ҮХ-2, ҮХ-3, ҮХ-4 маягтуудыг үндэслэх бөгөөд дээрх бүртгэл, маягтуудыг холбогдох санхүүгийн баримтын хамт

хадгална. Иймд Сангийн сайдын баталсан дээрх заавар маягтуудыг судлан үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид анхаарч, зааврын дагуу хэрэгжүүлж ажиллана.

3.5 Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчин

3.5.1 Илрүүлэлт:

Ээлжийн амралтын тооцоо, ээлжийн амралт олгох тухай мэдэгдлийг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалаар баталсан заавар, магтын дагуу тооцдоггүй байна.

Энэ нь эрх ба үүрэг, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалыг зөрчсөн байна.

3.5.2 Эрсдэл:

Хууль журмын хэрэгжилтийг хангаагүй байх.

3.5.3 Өгсөн зөвлөмж:

Ээлжийн амралт олгох тухай мэдэгдлийг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалаар баталсан заавар, маягтын дагуу үнэн зөв хөтлөх бөгөөд нягтлан бодогч уг мэдэгдлийг үндэслэн ээлжийн амралтын тооцоо, олговрыг бодож холбогдох санхүүгийн баримтын хамт хадгална.

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Ээлжийн амралтын тооцоог зааврын дагуу тогтмол тооцож ажиллана.

4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4,379,873.35	24,601,969.63
1.1.2	Дансны авлага	1,274,550.00	1,964,040.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	790,036.89	1,340,409.00
1.1.6	Бараа материал	55,387,205.35	73,504,139.72
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	61,831,665.59	101,410,558.35
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	4,782,940,390.98	4,663,363,334.88
1.2.9	Бусад үндсэн хөрөнгө	45,636,100.51	143,372,868.41
1.2.10	Бусад биет бус хөрөнгө	33,760,000.00	33,760,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,862,336,491.49	4,840,496,203.29
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,924,168,157.08	4,941,906,761.64
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	4,050.00	
2.1.1.3	Татварын өр	11,123,561.11	10,382,558.87
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	11,127,611.11	10,382,558.87
2.2	Өр төлбөрийн нийт дүн	11,127,611.11	10,382,558.87
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	1,589,231,349.17	1,698,941,149.17
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,777,697,343.48	3,777,697,343.48
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(453,888,146.68)	(545,114,289.88)
2.3.9.1	Тайлангийн үеийн ашиг / алдагдал /	(54,362,739.23)	(91,226,143.20)
2.3.9.2	Өмнөх үеийн ашиг / алдагдал /	(399,525,407.45)	(453,888,146.68)
2.3.11	Эздийн өмчийн дүн	4,913,040,545.97	4,931,524,202.77
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	4,924,168,157.08	4,941,906,761.64

АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	106,243,476.67	154,207,017.04
2	Борлуулалтын өртөг	12,045,832.73	13,314,226.42
3	Нийт ашиг(алдагдал)	94,197,643.94	140,892,790.62
4	Түрээсийн орлого	6,511,500.00	7,623,020.00
5	Хандивын орлого	1,158,435,080.00	
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	354,485,500.00	476,486,600.00
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,667,719,763.17	715,901,853.82
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	272,700.00	326,700.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(54,362,739.23)	(91,226,143.20)
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(54,362,739.23)	(91,226,143.20)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(54,362,739.23)	(91,226,143.20)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	(54,362,739.23)	(91,226,143.20)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Дүн
1	2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,487,381,899.17	3,777,697,343.48	(399,525,407.45)	4,865,553,835.20
2	НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-
3	Залруулсан үлдэгдэл	1,487,381,899.17	3,777,697,343.48	(399,525,407.45)	4,865,553,835.20
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(54,362,739.23)	(54,362,739.23)
5	Бусад дэлгэрэнгүй орлого				-
6	Өмчид гарсан өөрчлөлт	101,849,450.00			101,849,450.00
7	Зарласан ногдол ашиг				-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-
9	2018 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	1,589,231,349.17	3,777,697,343.48	(453,888,146.68)	4,913,040,545.97
10	НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-
11	Залруулсан үлдэгдэл	1,589,231,349.17	3,777,697,343.48	(453,888,146.68)	4,913,040,545.97
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(91,226,143.20)	(91,226,143.20)
13	Бусад дэлгэрэнгүй орлого				-
14	Өмчид гарсан өөрчлөлт	109,709,800.00			109,709,800.00
15	Зарласан ногдол ашиг				-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-
17	2019 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	1,698,941,149.17	3,777,697,343.48	(545,114,289.88)	4,931,524,202.77

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

	ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,627,519,005.51	640,744,210.04
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	110,294,818.00	157,249,511.31
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		168,000.00
	Татаас, санхүүжилтийн орлого	354,485,500.00	476,486,600.00
	Бусад мөнгөн орлого	1,162,738,687.51	6,840,098.73
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,488,505,338.79	605,248,983.76
	Ажиллагчдад төлсөн	212,530,204.00	248,392,229.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	63,022,771.00	76,834,939.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	300,204,753.03	64,001,939.12
	Ашиглалтын зардалд төлсөн	112,897,092.00	134,469,516.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	16,475,542.00	14,396,809.00
	Татварын байгууллагад төлсөн	35,772,000.89	25,364,610.76
	Даатгалын төлбөрт төлсөн	469,950.00	376,840.00
	Бусад мөнгөн зарлага	747,133,025.87	41,412,100.88
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	139,013,666.72	35,495,226.28
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,029,728.67	-
	Хүлээн авсан хүүний орлого	1,029,728.67	
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	148,352,510.00	15,268,130.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	148,352,510.00	15,268,130.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(147,322,781.33)	(15,268,130.00)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(8,309,114.61)	20,227,096.28
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	12,683,987.96	4,374,873.35
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,374,873.35	24,601,969.63